



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/173

Чойр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3, 6.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Суурин хүн амын 2024 оны хаврын улиралд хэрэглэх махны нөөцийг бүрдүүлсүгэй.


2.Махны нөөц бүрдүүлэхээр гэрээ байгуулсан аж ахуйн нэгжид олгох санхүүжилтийг хавсралтаар баталсугай

3.Дээрх зардалд шаардагдах 54,500,000 (тавин дөрвөн сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гэрээний дагуу гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

4.Нөөцийн бүрдүүлэлт, хадгалалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Э.Түвшинзаяа)-д үүрэг болгосугай

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаатар) даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4218400169

Аймгийн Засаг даргын 2024 оны
02 дугаар сарын 26 ны өдрийн
А/73 дугаар захирамжийн
хавсралт

Нөөц бүрдүүлэхэд шаардлагатай зардлын задаргаа

| № | Аж ахуй нэгжийн нэр | Махны төрөл | Хэмжээ кг | Санхүүжүүлэх дүн |
|----------|--------------------------|-------------|-----------|------------------|
| 1 | Сүмбэр буянт ХХК | Ямаа | 15000 | 28,000,000 |
| 2 | Очир мөнх хайрхан ХХК | Хонь | 15000 | 26,500,000 |
| Нийт дүн | | | 30000 | 54,500,000 |

